



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

e-journal

AMCHAM CSR

Issue 12 / March 2024





АЖЛЫН БАЙРНЫ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАГЧ АНХДАГЧ БАЙГУУЛЛАГА



emart

Имарт нэрээр илүүтэйгээр танигдсан Скай Хайпермаркет ХХК нь Монголын жижиглэнгийн худалдааны салбарт тэргүүлэгч компани юм. Манай компани нь дөрвөн салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа тасралтгүй явуулан ажлын байран дахь жендерийн эрх тэгш байдлыг чухалчлан хангасаар ирсэн билээ.

Имартын нийт 1200 ажилтны 70%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд цаашид илүү олон эмэгтэйчүүдийг чадавхжуулан, удирдах албан тушаалд дэвшин ажиллах боломжийг бий болгон ажиллаж байна.

Гүйцэтгэх захирал Л.Жавзмаа тэргүүтэй удирдлагын багийн 60%, С түвшний албан тушаалтны 50%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.



Гүйцэтгэх захирлын манлайлал, санаачилгын хүрээнд ажилтнуудыг чадавхжуулах Менторшип хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн. Үүний тод жишээ нь анх бичиг хэргийн ажилтнаар, худалдааны зөвлөхөөр тус тус ажлын гараагаа эхлүүлж байсан Б.Болормаа Санхүү хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (CFO), З.Баасанжаргал Борлуулалт, Үйлчилгээ эрхэлсэн дэд захирал (CSSO) болж өөрсдийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэн бататгаж, босоо шугамын дагуу карьер өсөлтийг гаргасан.

Түүнчлэн ажилтнуудынхаа ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг хангах хүрээнд ажлын уян хатан цагийн зохицуулалт, ажлын 4 өдөрт шилжих туршилт, ажилтнуудын хүүхдийн өрөө, хүүхэд хуурайлах өрөө, гэр бүлд ээлтэй бодлогуудыг баримталдаг бөгөөд үүнийгээ ч бусдад үргэлж уриалан түгээж байдаг. Тиймээс ч хүйсийн эрх тэгш байдал болон олон талт, хүртээмжтэй байдлыг дэмжих чиглэлээр манай байгууллагын хүчин чармайлтыг Азийн Хөгжлийн Банк үнэлэн Захиргаа, хүний нөөц эрхэлсэн дэд захирал Э.Халиуныг АХБ-ны Жендерийн форумд панелистаар урьж, хувийн хэвшлийн туршлагыг хуваалцахаар оролцуулсныг энд дурдахад таатай байна.

Бид ажилтнуудынхаа тав тухтай, таатай орчныг бүрдүүлэхийн зэрэгцээ жендерийн эрх

“ **Имартын нийт 1200 ажилтны 70%-ийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд цаашид илүү олон эмэгтэйчүүдийг чадавхжуулан, удирдах албан тушаалд дэвшин ажиллах боломжийг бий болгон ажиллаж байна.** ”

тэгш байдлыг бүрэн хангаж, ололт амжилтыг урамшуулан үнэлж ирсэн. Компанийн цогц аргачлал нь мэргэжлийн бүх тал дээр эрх тэгш байдлыг хангахуйц ажилтан бүр хүйс харгалзахгүйгээр карьер өсөлтийг хийж, өөрсдийн үнэтэй хувь нэмрээ оруулах боломжтой ажлын байраар хангахад оршдог.



НОГООН САНХҮҮЖИЛТ БОЛОН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ФОРУМ 2024



АмЧам, Капитрон банк хамтран ногоон санхүүжилт, ESG форумыг манлайлна. Улаанбаатар, Монгол Улс – АмЧам Монгол, Капитрон банктай хамтран 2024 оны 4-р сарын 2-нд болох “Ногоон санхүүжилт ба ESG” форумыг зохион байгуулахаар хамтран ажиллаж байгаагаа зарлаж байгаадаа баяртай байна. Энэхүү шинэлэг арга хэмжээ нь тогтвортой өсөлт, байгаль орчны хариуцлагыг дэмжих зорилготой юм. Байгаль орчин, тогтвортой хөгжил, засаглалын (ESG) асуудлуудын талаарх дэлхий нийтийн ойлголт өсөхийн хэрээр санхүүгийн байгууллагууд тогтвортой байдлыг үндсэн практиктаа нэгтгэх зайлшгүй шаардлага улам бүр тодорхой болж байна. Энэхүү форум нь салбарын тэргүүлэгчид, бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүдтэй яриа хэлэлцээ өрнүүлэх, санал бодлоо хуваалцах, Монгол Улсад ногоон санхүүжилтийн хөтөлбөрийг урагшлуулахын тулд түншлэлийг бий болгох талбар болно. “Ногоон санхүүжилт ба ESG” форум нь өргөн хүрээний сэдвүүдийг хамарсан панел хэлэлцүүлэг, үндсэн илтгэл зэрэг олон хөтөлбөртэй. Үүнд:

Монголд тогтвортой хөрөнгө оруулалтын боломжууд

Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад ESG шалгуурыг нэгтгэх

Ногоон санхүүжилтийн зохицуулалтын тогтолцоо, урамшуулал

Сэргээгдэх эрчим хүчний санхүүжилтийн шинэчлэл

ESG гүйцэтгэлийг хэмжих, тайлагнах шилдэг туршлагаууд

Энэхүү арга хэмжээ нь оролцогчдод салбарын мэргэжилтнүүдтэй ажил хэргийн яриа өрнүүлэх, хамтын үйл ажиллагааны талаар санал солилцох боломжийг олгоно. Дэлгэрэнгүй мэдээлэл болон бүртгэлийн дэлгэрэнгүй мэдээллийг АмЧам Монголын www.amcham.mn цахим хуудаснаас авна уу.



АмЧам Монголын тухай:

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.



Капитрон Банкны тухай:

Капитрон Банк нь Монгол улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудын нэг ба тогтвортой хөгжил, санхүүгийн инновацийг хөгжүүлж, компанийн нийгмийн хариуцлагыг өндөрт барьж ажилладаг хамт олон. Тогтвортой ирээдүйн төлөө ногоон эдийн засагт шилжих үйл явцыг дэмжиж, хүртээмжтэй өсөлтийг дэмжих зорилготой.

For media inquiries,
please contact:
AmCham Mongolia
Email: info@amcham.mn

Follow us on social media:
Twitter: [@AmChamMongolia](https://twitter.com/AmChamMongolia) | [@CapitrionBank](https://twitter.com/CapitrionBank)
LinkedIn: [AmCham Mongolia](https://www.linkedin.com/company/amcham-mongolia) | [Capitrion Bank](https://www.linkedin.com/company/capitrion-bank)



МОНГОЛ- ФРАНЦЫН ХАМТАРСАН “БАДРАХ ЭНЕРЖИ” ХХК ДОРНЫН ГОВЬД УСНЫ ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЖ БАЙНА

Францын Орано групп, Монгол Улсын төрийн өмчит “Мон-Атом” ХХК-ийн хамтарсан “Бадрах Энержи” компани нь Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт Зөөвч-Овоо ураны төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Говийн бүсийн иргэд, малчдын хувьд усны хүртээмж ихээхэн чухал болохыг мэдэхийн хувьд “Бадрах Энержи” компани нь усны хүртээмжийг сайжруулах санал санаачилгыг идэвхтэй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус компани Монгол улсад ажиллаж эхэлсэн цагаасаа сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төслүүдэд хөрөнгө оруулсаар ирсэн. Тэр дундаа 2006 оноос хойш нийт 8 тэрбум гаруй төгрөгийг нутгийн иргэдийн амьдралын тав тухтай нөхцөл, амьжиргааны түвшин, усны хүртээмж, боловсрол, эрүүл

мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад зарцуулжээ.

“Бадрах Энержи” компанийн зүгээс 2014 оноос хойш Улаанбадрах сум, Зүүнбаян багийн нутагт 64 худгийг сэргээн засварлаж, шинээр 6 худаг гаргаад байна. Ийнхүү малчдын худгийг сэргээн засварлаж, сайжруулснаар сум, орон нутгийн иргэд, ялангуяа мал сүргээ эдгээр худгаас ундаалдаг малчдын амьдралд бодитой нөлөө үзүүлсэн.

Малчдын худгийг сэргээн засаж, тоноглохдоо усны нөөц, чанар, урсац зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэн байж хийж гүйцэтгэдэг нарийн цогц ажил байдаг. Одоо байгаа худгуудийн 70 хувь нь 1970-аад оны үед ашиглалтанд орсон, засвар үйлчилгээ хийгдээгүй удсан зэргээс шалтгаалж, хуучирч муудсан байна.

“ 2006 оноос хойш нийт 8 тэрбум гаруй төгрөгийг нутгийн иргэдийн амьдралын тав тухтай нөхцөл, амьжиргааны түвшин, усны хүртээмж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад зарцуулжээ. ”

“Бадрах Энержи” компани сум, орон нутгийн иргэдтэй нягт хамтран ажилладаг бөгөөд орон нутгийн иргэд засаж, сайжруулах хурдгийг өөрсдөө сонгодог. Ийнхүү сонгосны дараа “Бадрах Энержи” компанийн гидрогеологийн баг худаг бүр дээр бүрэн үнэлгээ хийж, худаг байрлаж байгаа геологийн тогтоц, усны урсац зэргийг судалдаг. Эдгээр судалгаа, дүгнэлт дээр үндэслэн тухайн хурдгийн усны нөөц, ашиглалтыг сайжруулах ажлыг мөн хэрэгжүүлдэг байна.

Төслийн хугацаанд “Бадрах Энержи” компани орон нутгийн иргэд, удирдлагатай ойр хамтран ажиллахдаа эн тэргүүний хэрэгцээ шаардлагыг нь харгалзан үздэг. Төслийг хэрэгжүүлэх хугацаанд болон дараа нь хяналт хийж, гарсан үр дүнг үнэлж, дүгнэдэг.

Ийнхүү найдвартай, аюулгүй усны эх үүсвэрийг бий болгосноор “Бадрах Энержи” компани нь сум, орон нутгийн иргэд, малчдын амьдралд эерэг өөрчлөлтийг авчирч байна.





**Barloworld
Mongolia**



ЦАГААН САР – ХҮНСНИЙ АЯН

Бид Вэлүү Сангаас жил бүр зохион байгуулдаг Цагаан Сар – Хүнсний аянд уламжлал ёсоор оролцож, тус бүр 172,000 төгрөгийн үнэ бүхий 30 ширхэг хүнсний багц бэлдэн хандивлалаа. Энэхүү аянд бид сүүлийн хэдэн жил тасралтгүй оролцож байгаа юм. Хүнсний багцад өдөр тутмын хүнсний хэрэгцээний гурил, цагаан будаа, гоймон, ургамлын тос, цай, давс, сүү, аарц зэргээс гадна цагаан сарын тавгийн идээний ул боов, чихэр, ааруул багтсан юм. Уламжлалт сар шинийн баяраар эдгээр гэр бүл ах дүү, амраг садантайгаа учран золгоход нь бидний бяцхан хандив нэмэр болсон хэмээн итгэн бид ийнхүү жил бүр халуун сэтгэлээр оролцдог билээ.

ХАНДИВ - ЦАС ЦЭВЭРЛЭГЧ

Барловорлд Монголиа ХХК-аас “Ид шидийн орон” хүүхэд хамгаалал хөгжлийн төв болон “Кристина Нобле” сангийн асрамжийн газарт тус бүр 2ш цас цэвэрлэгч машин хандивлалаа. Эдгээр цас цэвэрлэгч машинууд нь их хэмжээний цасыг цэвэрлэх, ажилчдын цас цэвэрлэх ажлыг хөнгөвчлөх, улмаар тус байрыг хүүхэд, асран хамгаалагчдад аюулгүй, хүртээмжтэй байлгахад тусална хэмээн итгэж байна.



ХАНДИВ - ЧИНГЭЛЭГ

Барловорлд Монголиа ХХК нь мал амьтныг хамгаалах ажлын хүрээнд “UB Shelter” амьтан хамгаалах байранд тус бүр нь 40 тон жинтэй 2ш чингэлэг хандивлан тээвэрлэн хүргэж өгсөн билээ. Энэхүү хандив нь UB Shelter-д амьдарч буй амьтдыг аюулгүй, тав тухтай орчинд байлгахад, нэн ялангуяа Улаанбаатарын хатуу ширүүн өвлийн улиралд цагаа олсон дулаан бэлэг байсан гэдэгт эргэлзэхгүй байна.



DS MONGOLIA АНУ-ЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЖ БАЙНА.

АНУ-ын Засгийн Газраас эмэгтэйчүүдийн эдийн засгийг чадавхжуулах амлалт

АНУ-ын гадаад бодлогын гол цөмд жендэрийн тэгш байдлыг хангах нь стратегийн болон ёс суртахууны зайлшгүй чухал зүйл гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан эмэгтэйчүүдийн эрхийг хангах, эрх мэдлийг нэмэгдүүлэх нь тулгын чулуу болж байна. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Монгол дахь санаачилгууд нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг манлайлахад эмэгтэйчүүдийг чадавхжуулахад чиглэгдсэн энэхүү амлалтыг гэрчилж байна.

Жендэрийн тэгш, шударга байдал

Монголын бизнес эрхлэгчдийн 39.6%-ийг эмэгтэйчүүд тэргүүлж байгаа хэдий ч тэд эрэгтэй бизнес эрхлэгчидтэй харьцуулахад жижиг бизнесийн хэмжээ, ашиг орлого бага, гадаад санхүүжилтийн хүртээмж хязгаарлагдмал зэрэг томоохон саад бэрхшээлтэй тулгардаг. Уламжлалт үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн хэм хэмжээний дагуу зээл авах асуудал онцгой анхаарал татаж байна. Эдгээр тэгш бус байдал нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн өсөлтийн чадавхийг нээхэд чиглэсэн зорилтот дэмжлэг зайлшгүй шаардлагатайг онцолж байна.

Орон зайг нөхөх

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн БЕСТ хөтөлбөр нь 2023 онд эхлүүлсэн “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хөгжил” дэд үйл ажиллагаагаар дамжуулан өөрчлөлтийн хурдасгуур болсон. Хас Банктай хамтран Монгол Улс даяарх бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд чадавхийг бэхжүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ, зээлийг хөнгөвчлөх зэрэг чухал эх үүсвэрүүдийг ашиглах боломжийг санал болгож байна. Энэхүү дэд хөтөлбөр нь 103 бизнес эрхлэгч эмэгтэйд 6,157,280,000 төгрөгийн (ойролцоогоор 1.8 сая ам. доллар) зээл авах боломжийг олгож, Хас Банкнаас 50 сая

хүртэлх төгрөгийн барьцаагүй зээлийг санал болгож байна.

Санхүүгийн дэмжлэгээс илүү ихийг

Манай хөтөлбөрийн үр нөлөө нь дараахь байдлаар нэмэгдэж байгааг дуулгахад таатай байна.

- Хөдөө орон нутгийн 88 бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд 862 сая төгрөгийн (250,000 ам. доллар) буцалтгүй тусламжийг бэлнээр олгосон.

- Төслийн байршилд эмэгтэйчүүдийн гүйцэтгэх захирлын клубууд байгуулагдаж, харилцан суралцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор 235 бизнес эрхлэгч эмэгтэйн сүлжээг бий болгосон.

- Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Энтрепренёр эмэгтэйчүүд” чуулга уулзалт нь Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэж, эрх мэдэл, хамтын ажиллагааг дэмжих зорилготой юм.

- Судалгаа, түншлэлээр дамжуулан уг хөтөлбөр нь бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, санхүүгийн байгууллагууд болон бодлого

боловсруулагчид хоорондын утга учиртай яриа хэлэлцээг хөнгөвчлөх, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд илүү сайн үйлчлэх мэдлэг, стратегийг сайжруулдаг.

USAID-ийн BEST хөтөлбөр гэж юу вэ?

Бид хэн бэ?

- Тогтвортой байдал, ил тод байдлын төлөөх бизнесийн шилдэг нь (BEST) нь Хөгжлийн Шийдэл ТББ-аас хэрэгжүүлж буй таван жилийн (2020-2024) USAID-ийн санхүүжилттэй төсөл юм.

- Хөгжлийн Шийдэл нь бизнесийн хөгжлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллага бөгөөд Монголын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тулгарч буй бэрхшээлийн талаар гүнзгий ойлголттой болох замаар тэднийг чадавхижуулах зорилготой.

BEST хаана хүрдэг вэ?

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн BEST хөтөлбөр Монголд хэрэгжиж байна. Төслийн төв нь нийслэл Улаанбаатар хотод байрладаг бөгөөд 12 аймагт хөдөөгийн оффисууд байдаг.



BEST юу хийдэг вэ?

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн (USAID) санхүүжүүлдэг Тогтвортой байдал, ил тод байдлын төлөөх бизнесийн шилдэг хөтөлбөр (BEST) нь ЖДҮ-д олгох зээлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн засаглал, хариуцлагыг сайжруулах замаар Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, төрөлжүүлэхэд туслах зорилготой юм. ШИЛДЭГ хөтөлбөр нь дараах таван зорилтыг хэрэгжүүлэх замаар хэрэгжинэ: (i) ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх; (ii) ЖДҮ-ийн дунд компанийн засаглалыг сайжруулах; (iii) Монголын байгууллагуудын чадавхийг сайжруулах; (iv) стратегийн сургалтын аналитик хөтөлбөрийг хөтлөх; ба (v) боломжийн бэрхшээлтэй боловч бусад тохиолдолд чадвар сайтай жижиг аж ахуйн нэгжүүдэд хүрэхийн тулд жижиг буцалтгүй тусламж олгох.





ГОЛОМТ БАНК

Сайн сайхныг санхүүжүүлнэ


ГОЛОМТ БАНК “ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ” ТҮҮХ АРХЕОЛОГИЙН ТӨСЛИЙГ ГУРАВ ДАХЬ ЖИЛДЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА



үе шаттай судалснаар соёлын өвийг нарийвчлан тодорхойлж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох олон талт ажлыг хэрэгжүүлэх боломжтой юм. Тус хамтын ажиллагаа нь зөвхөн энэ төслүүдээр хязгаарлагдахгүй бөгөөд цаашид Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг арга зүйн дагуу шинжилж, гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүд дээр хамтарч, урт хугацаанд дэмжин ажиллана. ШУА-ийн

Археологийн хүрээлэн урьд өмнө санхүүжилтээс шалтгаалан малтлага, судалгааны ажлыг ихэвчлэн гадны байгууллагуудтай хамтран хийдэг байсан бол Голомт банк энэ салбарт хөрөнгө оруулалт хийсэн анхны дотоодын хувийн хэвшлийн байгууллага болсноороо онцлогтой.

Голомт банк “Өв соёлын голомт” түүх археологийн төслийг санаачилж, ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран 3 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Төслийн эхний ажил болох Хэрэйдийн Ван ханы ордон буюу Түргэний балгас-Туулын “Хар Түнэ Орд” дурсгалт газарт археологийн малтлага, судалгааны ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд Туулын Хар Түнэ Орд нь нийслэлийн бүс дэх түүх археологийн онцлох 5 дурсгалын нэг юм. Мөн Булган аймгийн Сэлэнгэ суманд байрлах Ингэт толгойн энгэр дэх хүн чулуун хөшөө, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумаас зүүн хойш 20км зайд орших Хэрлэнбаянцагаан уулын Монголын эзэнт гүрний үеийн булш, археологийн судалгааг тус тус хийж гүйцэтгээд байна.



Хэрэйдийн Ван ханы ордон



Түүхийн дурсгалт газрыг



ХААН БАНК

ХААН БАНК СӨҮЛ ОФФИСЫНХОО ЦАХИЛГААНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ 20 ХУВИЙГ НАРНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАЖ БАЙНА

ХААН Банк нь тогтвортой хөгжилд манлайлж, ногоон ирээдүйг бүтээлцэх зорилгынхоо хүрээнд нарны энергийг хуримтлуулж, цагт 22 кВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай нийт 48 ширхэг нарны хавтанг тус оффисын дээвэр дээр суурилууллаа. Үүнээс гадна цагт 11 кВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг ухаалаг шилэн фасадыг оффисын барилгын 224м. кв талбайд суурилуулсан нь Монголдоо анхдагч юм.





Ингэснээр 3000 ширхэг мод тарьсантай дүйцэх хүчилтөрөгчийг хэмнэх төдийгүй жилд ялгаруулах нүүрс хүчлийн хийг 40 тонноор бууруулах төлөвлөгөөтэй байна.

Түүнчлэн бид Сүүл оффисоос гадна Өвөрхангай аймгийн Хархорин, Төв аймгийн Лүн, Баянчандмань, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Айраг сумын тооцооны төвүүддээ нарны хавтан суурилуулаад байна. Ингэснээр орон нутаг дахь эдгээр салбар нэгжийн цахилгааны хэрэглээг 100% сэргээгдэх эрчим хүчээр хангах боломжтой болж буй.



“ХААН БАНК”-НЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЯНУУД

Үндэсний хэмжээний томоохон банкны хувьд ХААН Банк нийгмийн хариуцлагын хүрээнд олон төсөл хөтөлбөр, аянуудыг уламжлал болгон урт хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж ирснээс Хавдрын эсрэг үндэсний аян, Цусны даралт ихсэлтийн эсрэг аян өдгөө олон нийтэд хэдийн танигдаж, орон даяар иргэд, харилцагчид бодит үр шимийг нь хүртэж, эрүүл саруул болсон жишээ цөөнгүй билээ.

ХАВДРЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ АЯН

ХААН Банкны Сангаас уламжлал болгон хэрэгжүүлдэг “Хавдрын эсрэг үндэсний аян”-ыг олон нийтэд хорт хавдраас сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрсдэлт бүлгийн хүн амыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах, эрт үед нь оношилж, эмчлэх, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хорт хавдрын эрт илрүүлэг, хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр сургах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгын дор 13 дах жилдээ амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023 онд тус аяны хүрээнд Дорнод, Увс аймагт ажиллан 3000 гаруй үзлэг хийж, 26 хортой хавдар, 305 хоргүй хавдрыг илрүүлэн, нийт 13 жилийн хугацаанд 133 мянга гаруй иргэдийг үзлэг оношилгоонд хамруулан ард иргэдийн эрүүл мэндийг дэмжин ажиллаад байна.



ЦУСНЫ ДАРАЛТ ИХСЭЛТИЙН ЭСРЭГ АЯН

Цусны даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийг үзлэг оношилгоонд хамруулах, мэдлэг мэдээлэл олгох зорилгоор 2017 оноос хойш П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг (УГТЭ)-ийн санаачилга, ХААН Банк сангийн санхүүжилт дэмжлэгтэйгээр Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ), Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ)-тэй хамтран “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян”-ыг уламжлал болгон зохион байгуулж ирсэн билээ.

ХААН Банкны нийгмийн хариуцлагын уламжлалт томоохон төслийн нэг болох “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян”-аа 2023 онд Дундговь, өвөрхангай, Завхан, Говь-Алтай аймгуудад хэрэгжүүлсэн.

Аяны үеэр уламжлал ёсоор цусны даралт ихсэлт, түүний эрсдэлт хүчин зүйлийн тухай эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт явуулж, зорилтот бүлгийн иргэдэд цусны даралт ихсэлтийн эрт илрүүлгийн үзлэг оношилгоо, зүрх судас, зүрхний шигдээс, мэдрэл, тархины цус харвалт, бөөр, хоол боловсруулах замын эмгэгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 22,300 гаруй иргэнийг хамрууллаа. Мөн орон нутгийн 300 эмч, мэргэжилтний дунд чадавхжуулах сургалт зохион байгуулж, цусны даралт ихсэлтийг эрт илрүүлэх, оношлох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хүн амын дундах даралт ихсэлтийн шалтгаан, нөхцөлийн талаар судалгаа хийв. Ийнхүү тус хөтөлбөрийн хүрээнд 7 жилийн хугацаанд нийт 17 аймгийн 41,300 хүнд эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийж ажилласан байна.





Монголын ирээдүй болсон ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДАД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ

Лоринэт Сан нь туслалцаа, дэмжлэг шаардлагатай байгаа Монгол Улсын хүүхэд залуус, гэр бүлүүдийн амьдралд тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой.

Бид нийгмийн үр нөлөө бодитоор авчирч байгаа шинэлэг төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэхээс гадна дараах хоёр чиглэлд үр нөлөө бий болгохын төлөө ажилладаг.

Үүнд:

- Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэнээр гарах шууд үр нөлөө
- Үндсэн чиглэлүүдийнхээ хүрээнд холбогдох мэдлэг, мэдээллийг боловсруулан түгээж, олон талт хамтын ажиллагааг бэхжүүлж, урт хугацааны тогтвортой үр өгөөж авчирдаг сайн туршлагауудыг нэвтрүүлснээр бий болгох системийн түвшний үр нөлөө

ЯАГААД БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АСАРГАА ХАЛАМЖ БА БОЛОВСРОЛ ЧУХАЛ ВЭ?

Хүүхэд эхээс мэндэлсэн цагаас эхлэн тав хүртэлх насны үе нь тархины хөгжил эрчимтэй явагддаг төдийгүй цаашдын өсөлт хөгжил, ирээдүйд амжилттай суралцах, сайн сайхан амьдрах үндэс суурь нь тавигддаг чухал үе болохыг олон улсын судалгаанууд нотолсоор байна. Аливаа хүн бага насандаа эрүүл саруул, аюулгүй орчинд өсөж торнин, сурч хөгжиж чадвал, өөрийн нөөц бололцоогоо бүрэн дайчилж, улмаар нийгэм, эдийн засаг, соёлын харилцаандаа амжилт гаргана гэж үздэг. Монгол Улсад бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, ялангуяа зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдэд дутмаг хэвээр байна.



ЯАГААД ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ ЧУХАЛ ВЭ?

Хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн олон залуу хүн амьдарч байгаа өнөө цаг үед, ихэнх хөгжиж буй орнуудын хувьд залуучуудын ажилгүйдэл хамгийн тулгамдсан асуудлын нэгт тооцогдож байна. Дэлхийн Банкны мэдээлснээр 2021 онд монгол залуучуудын 17.2 хувь нь хөдөлмөр эрхлээгүй, мөн боловсрол сургалтад хамрагдаагүй байжээ. Хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх нь эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд төдийгүй туршлага, ур чадвар багатай залуучууд зэрэг нийгмийн бүлгүүдийн хувьд илүү бэрхшээлтэй байдаг. Үүний улмаас залуучууд ихэвчлэн цалин хөлс багатай, ажлын орчин сайнгүй, албан бус салбарт ажилд ордог байна.



ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

Бага насны хүүхдийн асаргаа халамж ба боловсрол



Уанскай Монгол: Монгол эцэг эх, асран хамгаалагч нарын хүүхдээ асарч халамжлах ур чадварыг нэмэгдүүлэх нь (2020 оноос хойш хэрэгжиж байгаа)

Энэхүү төсөл нь гэр хороололд оршин суудаг бага насны хүүхдүүд чанартай хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэхийн сацуу гэр бүлүүдийн хоорондын харилцааг бэхжүүлж, хүүхдийн хөгжилд нэг нэгэндээ дэмжлэг, туслалцаа үзүүлдэг хөршийн холбоог бий болгох зорилготой.



The Asia Foundation

Монгол дахь Азийн Сан: Монгол Улсад номоор дамжуулан бага насны хүүхдийн хөгжил, боловсролыг дэмжих нь (2021 оноос хойш хэрэгжиж байгаа)

“Хамтдаа уншицгаая” төсөл нь эцэг эх, асран хамгаалагч, багш нар болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэгчдэд бага насны хүүхэдтэй хамтдаа ном унших дадлыг сурталчилж, улмаар номыг хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал хэрэгсэл болгон ашиглахад туслалцаа зорилготой.



Залуучуудын хөдөлмөр эрхлэлт



Зорис Сан: Монгол залуучуудыг боловсролоос хөдөлмөр эрхлэлт рүү шилжихэд дэмжлэг үзүүлсэн нь (2019 – 2022)

“Залуусын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь их, дээд сургуулиа төгсөөд хагас жилээс дээш хугацаа өнгөрч байгаа ч ажилд орж чадаагүй залуучуудын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн хөтөлбөр юм. Бид Улаанбаатар хотын гэр хороололд амьдардаг эсвэл аймаг, орон нутгаас нийслэл хот руу шилжин суурьшсан залуучуудыг голчлон хөтөлбөртөө хамруулсан.



Дэлхийн Зөн Монгол: Гэр хороололд оршин суугаа залуу гэр бүлүүдийн өрхийн амьжиргааг дэмжсэн нь (2018 – 2022)

“Залуу гэр бүлийн өрхийн амьжиргааг дэмжих төсөл” нь гэр бүлийн чадавхыг аажмаар сайжруулах замаар тэдний онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, өрхийг ядуурлаас гаргах зорилготой. Энэхүү хөтөлбөрөөр Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн гэр хороололд амьдран суугаа 150 залуу гэр бүлүүдийг чадавхжуулав.

Нийгмийн хөрөнгө оруулалт нь Монгол Улсыг хүртээмжтэй болон тогтвортой хөгжихөд чухал хувь нэмэр оруулах боломжтой. Тиймээс бид бий болгож буй үр нөлөөгөө тэлэн нэмэгдүүлэхийн тулд хамтын үнэ цэнэ бүтээх сонирхолтой хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллахад нээлттэй байх болно.

Хамтын ажиллагаа болон манай сангийн талаар дэлгэрэнгүй мэдэхийг хүсвэл дараах хаягуудаар холбогдоно уу dashnorov.oyuntugs@lorinetfoundation.org, <https://www.lorinetfoundation.org/>.



RioTinto

РИО ТИНТО МОНГОЛ КОМПАНИ “ЭРҮҮЛ ОЙ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 300,000 ГА ОЙГ БИО БЭЛДМЭЛЭЭР ЭМЧИЛЖ, МОНГОЛ ОРНЫ ОЙН САНГ ХАМГААЛАХ АЖЛЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.

Рио Тинто Монгол компани Монгол орны ойн санг хамгаалах “Эрүүл ой” төслийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Америкийн Нэгдсэн Улсад төвтэй Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж байна.

“Эрүүл ой” төсөл нь 2025 он хүртэл үргэлжлэх бөгөөд нийт 300,000 га ойд тэмцлийн ажлыг явуулах юм. 2023 оны хувьд нийт 5 аймгийн 15 сумын нутаг дэвсгэр дэх 150 мянган га ойд хөнөөлт шавжийн тархалтыг бууруулах зорилгоор эмчилгээний био бэлдмэлийг агаараар болон газраар цацаж доройтолд орж үхэх аюулд орсон олон сая моддыг аварлаа.

Энэхүү төслийн бас нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь 1990 онд ардчилсан нийгэмд шилжсэнээс хойш орхигдоод буй хүний нөөцийн чадамжийг бэхжүүлэх, “ойн эмч” нарыг бэлтгэх явдал юм. Эдгээр бэлтгэгдсэн мэргэжилтнүүд ойн урт хугацааны эрүүл мэнд, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм. Энэ жил Microsoft-ийн үүсгэн байгуулагч Пол Аллены Хиймэл Оюун Ухааны Институтийн хөгжүүлсэн хиймэл оюун ухаанд суурилсан хамгийн сүүлийн үеийн технологи болох “EarthRanger” программыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Тус программ нь ой хамгаалагчдын ирүүлсэн бодит мэдээлэл, алсын зайн дүрслэл, мэдрэгч технологи зэргийг ашиглан ойн хяналт, мониторингийн ажлыг



шинэ түвшинд авчрах шилдэг технологи юм.

Монгол орны нийт газар нутгийн ердөө 7.9 хувийг ойгоор бүрхэгдсэн талбай эзэлдэг. Бүгд Найрамдах Хятад Улсын нийт газар нутгийн 24%, Америкийн Нэгдсэн Улсын нийт газар нутгийн 34%, Европын Холбооны улсуудын дунджаар нийт газар нутгийн ойгоор бүрхэгдсэн талбай нь 40% байдаг. Гэтэл Монгол орны газар нутгийн маш бага хувийг эзэлдэг ой мод аюулд өртжээ.

Ой мод нь нүүрстөрөгчийг шингээж, хөрсний доройтлоос урьдчилан сэргийлэх, усны экосистемийг хадгалах замаар уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад чухал

үүрэг гүйцэтгэдэг. Уур амьсгалын дулаарлаас үүдэлтэй ойн хөнөөлт шавж үржихэд таатай нөхцөл бүрдэж, улмаар хэт олширч, ойн нөөц их хэмжээгээр хомсдох аюулд орсон юм.

“Эрүүл ой” төсөл нь Монгол орны ойн экосистемийн төлөв байдлыг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицсон ойг бий болгоход чухал дэмжлэг үзүүлэх төсөл юм.



“Малчид өглөө хотондоо орохоос ч айдаг болсон” хэмээн хоолой зангиран ярьж байна. Тал газрын төмөр зуд цас шуурч хунгарлан, хатуурч, ухсан ч дороос нь мөс гарч ирнэ. Өвөл цагт адуу цас цавчиж, өвс олж иддэг бол одоо цасан дороос мөс гарч ирнэ. Малын хамар хатгах өвс байтугай хөлтэй амьтан гишгэх газаргүй хөлгүй далай шиг их цастай байна.



**Нүүдлийн мал аж
ахуйд шинэчлэл
хийх, хагас суурин
маллагаатай болгох,
тооноос чанарт
шилжих зэрэг
шийдэх асуудлууд
олон байна.** ””

Өвлийн сар өнгөрсөн ч хөр цас, хүйтэн жавар өвлийнхөөрөө. Малчид цаг хүндрэхийг намар эрт мэдэж малынхаа талыг шахам цөөлж бойлсон ч үлдсэн хэдийг нь мэнд оруулах гэж үнэндээ л цөхөрч байна. Гэрийнхээ ихэнх зайг хашаа болгоод үлдсэн хэдийгээ тэжээж байна.

65 сая малаас хэд нь үлдэх бол? Мал зогсоогоороо, хэвтээгээрээ осгож, өлдөж үхсээр.

Зүүн аймгуудад хотоо харлуулсан малчид олон байна. Хот нь харлаж, малгүй хоцорсон малчид ирэх хавраас яахыг бүү мэд. Эхнээсээ сумын төв бараадаж эхэлжээ. Хөдөөнөөс сумруу, сумаас аймаг, хотруу шилжилт хөдөлгөөн эрчимжих байх.

Аймгаас сум, багруу боломж бололцоогоороо зам гаргаж байна. Гэвч гаргасан зам удахгүй шуурсан цасанд дарагдана. Машин

тэрэг явах боломжгүйгээс сумаас өвс тэжээлээ авах нь битгий хэл түлээ түлшээ татаж чадахгүй гал алдаж байна. Унаа явах боломжгүй уулын мухарт хэдэн малтайгаа зутарч суугаа олон малчин байна.

Нүүдлийн мал аж ахуйд шинэчлэл хийх, хагас суурин маллагаатай болгох, тооноос чанарт шилжих зэрэг шийдэх асуудлууд олон байна. Дахиад ч зуд болно. Аль болгон нэг зуднаар байдгаа барах вэ? Угтаа бол хэдэн малчдын асуудал биш. Хүнсний аюулгүй байдал, мал аж ахуйн салбарын асуудал яригдана. Бодлогын түвшинд дорвитой ажиллаж малын өвчнөөс салж, мал махаа экспортод гаргадаг тогтолцоотой болбол асуудал өөрөөр яригдана.

Энэ жил төл авч, ямаа самнах айл тун цөөхөн байх нь. Удалгүй мах, цагаан идээний үнэ ч өснө. Цаг наашилж байна. Сэтгэлийн хаттай, итгэлийн нөмөртэй байгаарай малчид минь!



“
**Гэрийнхээ ихэнх зайг хашаа болгоод
үлдсэн хэдийгээ тэжээж байна.**”

